

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
(Баян-Өлгий аймгийн ЭМГ 2025 он)

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	450	Гүйцэтгэлээр 420	Тайлангийн жилд 420 удаагийн сургалтад 20 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 3200 гаруй эрүүл мэндийн ажилтан хамрагдаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтнүүд эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн мэдээллийн систем /hrds (hdc.gov.mn) /программаар хүсэлт илгээж сургалтад хамрагдаж багц цагаа бүрдүүлсэн. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн багц цагийн биелэлт 83% тай байна. Багц цагийн биелэлтийн хувь Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан бөгөөд сургалтад хамрагдсан Үр дүн. Сургалтад хамрагдсан албан хаагчид сурсан мэдлэг, ур чадвараа орон нутагт хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан. Сургалтын тогтолцоог цахим хэлбэрээр шилжсэнээр оролцооны хүртээмж нэмэгдэж, багц цагийн биелэлтийн хувь нэмэгдсэн. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд зориулсан төсөв хасагдсаны улмаас зарим байгууллага төлөвлөсөн зорилтот сургалтаа зохион байгуулах боломжгүй болсон. Хэрэгжилтийн хувь 93 %

		Үүнэ эс	Ажлын байран дахь сургалт	150	120	Эрүүл мэндийн газраас салбарын албан хаагчдад чиглэсэн дараах сургалтууд хийгдсэн байна. Үүнд: 1. Авлигын эсрэг нэгдье” арга хэмжээний хүрээнд авлигын эсрэг соён гэгээрүүлэх, мэдлэг олгох 1 удаагийн сургалтад 150 эрүүл мэндийн ажилтан, 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэсэн Dgital-first V –р аяны хүрээнд явагдсан 4 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын давхардсан тоогоор 250 гаруй эрүүл мэндийн ажилтан оролцов. 3. Хяналт шалгалтын хэлтсийн 4 улсын (ахлах) байцаагч нар хяналт шалгалтын явцад давхардсан тоогоор 116 байгууллага, аж ахуйн нэгжийн 855 хүнд зориулан 15 удаагийн салбарын сургалт зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн. 4. Сумын эрүүл мэндийн төвүүдийн холбогдох ажилчдын 60 хувийг нялх, бага насны хүүхдийг хооллох талаар зөвлөгөө өгөх ур чадварт сургах зорилгоор НҮБ-ийн Хүүхдийн сан болон Эрүүл мэндийн газрын санхүүжилтээр 5 хоногийн сургалтыг 4 удаа зохион байгуулж, нийт 91 эмч, ажилчдыг хамруулсан. 5. Багийн бага эмч нарын эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 05, 09 дүгээр саруудад 2 хоногийн 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 48 эмч хамрагдсан. Мөн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн төвүүдийн ЭМТҮЧАБ-ын багуудын гишүүдийн эрүүл мэндийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах мэдлэг, хандлагыг өөрчлөх, чадавхжуулах зорилгоор 2025 оны 11, 12 дугаар саруудад сум, өрхийн ЭМТ болон хувийн эмнэлгүүдийн ЭМТҮЧАБ-ын багуудын гишүүдийг хамруулсан 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон 2025 оны байдлаар эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтнуудад зориулсан 6. “Сэтгэц, мэдрэл, донтолт (СМД)-ын тусламж
--	--	------------	------------------------------	-----	-----	--

					үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх”, “Эмнэлгийн эрх зүй ба Ёс зүй” , “Стресс менежмент” , “Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх”, Багийн бага эмч нарын эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний мэдлэгийг дээшлүүлэх, “Эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын багийн эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах , 7. “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний мэдлэгийг сайжруулах”, ахмад настны цогц тусламж үйлчилгээ, Лабораторийн эмч, лаборант нарыг чадавхжуулах, "Нялх, бага насны хүүхдийн хооллолтын байдалд зөвлөгөө өгөх ур чадвар”, Ариутгагч нарыг чадавхжуулах сургалт, "Монгол уламжлалт анагаах ухааны хөгжил-орон нутагт", “Мэргэжлийн ёс зүй”, “Эрүүл мэндийн үйлчилгээний стандарт”, “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага (MNS-7014:2023)”, “Мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага” зэрэг сэдэвт давхардсан тоогоор танхимын болон цахим сургалтад аймгийн төвийн болон сумдын 1600 гаруй эрүүл мэндийн ажилтан, 8. Глобаль сангийн санхүүжилтээр Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд аймгийн 12 сум, 1 тосгоны Эрүүл мэндийн төвөөс тус бүр 3 эмч оролцож, сургалт, хэлэлцүүлгийг Толбо, Улаанхус сумдад амжилттай явуулсан. 9. Төрийн албан хаагчийн ёс зүйн 1 удаагийн сургалтад давхардсан тоогоор 56 албан хаагч 10. Хүний папилома вирусийн эсрэг вакцины чиглэлээр анхан шатны 13 байгууллагын эрүүл мэндийн байгууллагын 324 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн хувь Сувилахуйн тусламжийн үйлчилгээ, Тоног төхөөрөмжийн ашиглалт, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилт, Эрсдэл тохиолдол, Чанарын арга хэрэгсэл, Байгууллагын соёл, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Хөдөлмөрийн харилцаа, Эмийн зохистой
--	--	--	--	--	--

						хэрэглээ, Эрүүл ахуй, халдвар хамгаалал ХАБ, “Цахилгааны аюулгүй байдал” “Галын аюулгүй байдал ” “Үйлдвэрлэлийн осол ХХСБД”, гэх мэт. Сэдвүүдээр сургалт тогтмол явагдсан. Хэрэгжилтийн хувь 90%
			Мэргэшүүлэх сургалт	80	85	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Эрүүл мэндийн ажилтны 2025-2026 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл,хяналтын тоо батлах тухай “А/251 дүгээр тушаалын дагуу улсын төсвийн санхүүжилтээр үндсэн мэргэжлийн сургалтад 12 их эмч, Төрөлжсөн мэргэшлийн 6 сараас 1 жилийн сургалтад 14 их эмч, Мэргэжил дээшлүүлэх сургалтад 8 эмч, Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний 3 сарын мэргэшлийн сургалтад 18 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. Мөн АШУҮИС-ийн эм зүйн зохион байгуулалтын сургалтад 6 эм зүйчийг элсүүлэн сургалцуулах хүсэлт гаргаж, хувийн эмийн сан Эм ханган нийлүүлэх байгууллагуудын эм зүйчид суралцаж байна. Мөн сумын эрүүл мэндийн төвийн удирдах албан тушаалтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 4 удирдах албан тушаалтан хамрагдсан Хэрэгжилтийн хувь 85 %

			Туршлага солилцох арга хэмжээ	5-аас доошгүй	6	Аймгийн нэгдсэн эмнэлэг тайлангийн жилд эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан ажлын байрны сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Үүнд: Төрөх тасгийн хоёр эх баригч Япон Улсын Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яамны хэрэгжүүлж буй “Эмнэлгийн технологийг олон улсад түгээхийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Японы сувилахуйн сургууль, Токиогийн эх баригчдын танхим, Токиогийн Эрүүл мэндийн их сургуультай хамтран зохион байгуулсан “Монголын эх баригчдын төрөлтийн үеийн тусламж үйлчилгээний ур чадварыг сайжруулах, төрөх замын урагдал халдвараас урьдчилан сэргийлэх” сэдэвт онол, дадлага хосолсон хоёр багц цагийн сургалтад 9-р сарын 13–14-нд оролцов. Мөн мэс заслын сувилагчдын хоёрдугаар чуулга уулзалтад нүдний хагалгааны нэг сувилагч хоёр хоногийн сургалтад хамрагдсан. Лавлагаа шатлалын болон БОЭТөвд зохион байгуулсан “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалт” сэдэвт сургалтад өсвөр үе, залуучуудад ээлтэй кабинетын сувилагч оролцсон.
			Бусад	30-аас доошгүй		
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	1160	920	2. Анхан шат болон хоёр шатлалын эмнэлгүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, арга зүйгээр хангах зорилгоор Толбо сумын ЭМТ-ийн эмч, сувилагчдад “Амилуулах суурь тусламж”, “Уян зүү тавих арга зүй”, “Шээлгүүр тавих”, “Ходоодны зонд тавих”, “ЗЦБ хийх” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 19 хүн хамрагдсан.
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	866	690	
			Эрэгтэй албан хаагч	290	230	

			Удирдах албан тушаалтан	22	16	Мөн “Цэнхэр код идэвхжүүлэх – амилуулах суурь тусламж” сэдвээр хувийн хэвшил, ӨЭТөв, СЭТӨв-ийг хамруулсан ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж, нийт 95 мэргэжилтэн оролцсон. 
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1128	860	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	90 %	
						3. Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийг тохиолдуулан сувилагч, эх баригч нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Сувилагч тандаа баярлалаа-2025” уриатайгаар 5-р сарын 12-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд улсын хэмжээнд 800 гаруй мэргэжилтэн оролцсон бөгөөд манай аймгаас нийт 9 хүн, үүнээс нэгдсэн эмнэлгээс 4 хүн хамрагдав. 
						4. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Гэр бүл төлөвлөлтийн 5 хоногийн сургалтад 1 эх баригч, “Эхийн сүүгээр хооллох 10 алхам” сэдэвт 5 хоногийн сургалтад нярайн сувилагч, Эх баригчдын нийгэмлэгээс зохион байгуулсан Олон улсын эх баригчдын өдрийн нэгдсэн арга хэмжээ болон лавлагаа шатлалын эмнэлгийн эх барихуйн тусламжийн сэдэвт үйл ажиллагаанд эх баригч нар тус тус оролцсон.



6.Сүрьеэгийн тасгийн лаборант ХӨСҮТ-д шинээр ирсэн Genexpert аппарат, “XDR, TRUNAT аппаратаар шинжилгээ хийх арга зүй” сэдэвт 3 өдрийн сургалтад хамрагдаж мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлсэн бөгөөд Genexpert аппаратаар 1–10 насны хүүхдийн өтгөнөөс сүрьеэ илрүүлэх шинжилгээ хийх мэдлэгтэй болсон.

Сүрьеэгийн тасгийн эм хариуцсан сувилагч нь эмийн ханган нийлүүлэлтийн нэгдсэн менежментийн аргачлал сэдэвт нэг өдрийн сургалт, ОДЭС-ийн эмийн орлого, зарлага, захиалга хийх талаар хоёр өдрийн сургалтад тус тус хамрагдсан.

Сүрьеэгийн тасгийн ээлжийн сувилагч нь ОДЭС-тэй өвчтөний эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх талаар хоёр өдрийн сургалтад хамрагдсан.

Мөн ажлын байрны сургалтын төлөвлөгөө боловсруулж, нэг улиралд 4 сэдвээр нийт 10 удаа сургалт зохион байгуулж, сувилагч, мэргэжилтнүүд оролцон мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн..

1. “ Эрт сэрэмжлүүлэх ба эрэмблэн ангилалт” сэдэвт сургалтанд 70 сувилагч
2. “ Ижил мэргэжилтний үнэлгээ хийх арга зүй” сэдэвт сургалтанд -53 сувилагч
3. ЭМСС-ын 2015 оны 189дүгээр тушаал “ Ажлын байранд нийтлэг мөрдөх журам”-70сувилагч
4. “Гарын эрүүлэхуй”- 21 сувилагч
5. “ Өвдөлтийн үнэлгээ”- 12сувилагч
6. “ Шинэ сувилагчийг дадлагажуулах журам”- 69 сувилагч
7. “ Хог хаягдлын ангилал”- 21 сувилагч

8. “Менингококкын халдвар”- 10 сувилагч



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: 1-улиралд тохиолдолын хэлэлцүүлэг 2 удаа чанарын албатай хамтран хийсэн. Хүүхдийн тасаг, мэс заслын тасаг, эм зүйн алба, нярайн сувилагчид оролцсон



Ажлын байрны сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу 9 сэдвээр 8 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 713 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.

1. “Ажлын байранд нийтлэг мөрдөх журам” – 70 сувилагч
2. “Тарилга хийх стандарт” – 84 сувилагч
3. “Тарианы өрөөний эмх цэгц, тарианы тэргэнцэрийн бэлэн байдал” – 84 сувилагч
4. “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал” – 150 сувилагч
5. “Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын нууцын гэрээ” – 84 сувилагч
6. “Эрсдэлийн үнэлгээ хийх, тохиолдлыг бүртгэх” – 84 сувилагч
7. “Шинэ сувилагч дадлагажуулах журам” – 69 сувилагч
8. “Эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх, онош тавих, төлөвлөгөө боловсруулах арга” – 22 сувилагч



9.Амилуулах суурь тусламж болон лавшруулсан тусламж үйлчилгээ-66



10. АУ-ны доктор, профессор С. Наранчимэг, СУ-ны докторант, клиникийн профессор С. Нармандах багш нар “ MNS7014:2023 стандарт”-ын хэрэгжилтийг хангаж эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор

- 1.”Анагаах ба сувилахуйн мэргэжилтний ёс зүйн онцлог, үнэ цэнэ үнэт зүйл,бахархал”
2. “Эрүүл оршихуй”- СӨБ-ийн багш, сэтгэл зүйч нарт
3. “Мэргэжлийн ёс зүй, харилцааны ур чадвар, мэргэжлийн үнэ цэнэ”
- 4.”Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS7014:2023 стандарт”
5. “ Сэтгэл ханамжтай үйлчлүүлэхэд иргэдэд өгөх зөвлөмж”-олон нийтэд зориулсан теле ярилцлага
- 6.” Нотолгоонд суурилж хөгжих арга зүй- Үйлийн судалгааны аргыг ашиглах” сэдвүүдээр 3 өдрийн сургалтыг танхимын хэлбэрээр явуулж эрүүл мэндийн үйлчилгээний онцлог, стандарт, эрүүл мэндийн үйлчилгээнд эерэг

						өөрчлөлт гаргах арга замыг эмч, сувилагч эмнэлгийн нийт албан хаагчид оролцов. Хэрэгжилтийн хувь 85 %
Хэрэгжилт 88.2 хувь						
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	6	17	Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор дотоод болон гадаадын богино, урт хугацааны сургалт, туршлага солилцоонд хамруулсан. Үүнд: сэргээн засах судлалын эмчийг улсын төсвийн санхүүжилтээр БНХАУ-ын Алтай хотод богино хугацааны сургалтад, нүдний их эмчийг Турк Улсын Дунягөз нүдний эмнэлэгт “Мэс заслын клиник”-ийн чиглэлээр 10 хоногийн сургалтад, дурангийн их эмчийг БНСУ-ын UVON эмнэлэгт орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлээр 10 хоногийн сургалтад тус тус хамруулсан. Хүүхэд, нярайн их эмч 2, сувилагч 2-ыг БНКазахстан Улсын Астана хотын Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвд 10 хоногийн хугацаанд туршлага солилцох сургалтад, ЗӨСТөвийн халдвар судлагч их эмч “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хил орчмын бүс дэх тарваган тахлын байгалийн голомтын орчин үеийн төлөв байдал” эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ОХУ-ын Эрхүү хотын Алс Дорнод Сибирийн Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэнд ЗӨСҮТ, ОХУ-тай хамтран зохион байгуулсан “Хил дамнасан байгалийн голомтод тарваган тахал өвчний тархвар судлалын тандалт, лабораторийн оношилгооны өнөөгийн асуудал” сэдэвт эмч нарын мэргэжил дээшлүүлэх богино хугацааны давтан сургалтад хамруулсан. Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 1 мэргэжилтэн 2 жилийн магистрын сургалтад суралцаж байна. Мөн БНСУ-ын эрүүл мэндийн салбарын тогтолцоо, байгууллагуудын туршлага судлах уулзалтад ЭМГазрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч оролцсон. Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг нь Турк улсын Medical Park эмнэлэгтэй хамтран “Зүрх судасны оношилгоо, эмчилгээний чиглэлийн онлайн цуврал сургалт”-ыг амжилттай зохион байгуулсан.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	15	37	
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	10	24	
			Эрэгтэй албан хаагч	5	12	
			Удирдах албан тушаалтан	0	3	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	0	33	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	1,5 %	3%	

					Сургалтад аймгийн зүрх судас, дотор, яаралтай тусламж, хүүхэд, гэмтлийн чиглэлийн нийт 27 эмч хамрагдсан. Нийт 7 удаагийн онлайн хичээлийг Medical Park эмнэлгийн туршлагатай кардиолог эмч нар удирдан явуулсан бөгөөд онолын мэдлэг, практик кейс, дүрс оношлогооны материал, асуулт-хариултын хэлэлцүүлэг багтсан. Сэдвүүдэд: зүрхний цахилгаан бичлэг (ECG) ба хэм алдагдлын оношилгоо, яаралтай үед ECG-д тулгуурлан шийдвэр гаргах, клиник кейсүүдээр дадлага хийх; ачаалалтай зүрхний эхокардиографи (Stress Echo)-ийн зорилго, заалт, эсрэг заалт, ишемийн ЭХО өөрчлөлтийн тайлбар, дүрс бичлэгт суурилсан кейс судалгаа; титэм судсан доторх оношилгоо ба эмчилгээний үндэс сэдэвийн хүрээнд зохион байгуулсан сургалт болон туршлага солилцооны арга хэмжээнд хамрагдсан эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварын түвшин дээшилж, тэдгээрийг оношилгоо, эмчилгээний үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Биелэлт 90%
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	Төрийн зардлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын үндсэн цалинг Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтаар 5 жил тутамд мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 56/97 дугаар хамтарсан тушаалын дагуу 3 хүртэлх сарын үндсэн цалин, замын зардлыг үндсэн байгууллагаас гэрээний дагуу 30 гаруй эрүүл мэндийн ажилтанд 65 сая төгрөг, Мөн Улаанбаатар хот БОЭТөв, аймгийн төвд зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд, албаны томилолтоор ажилласан албан хаагчдад эхний 11 сарын байдлаар 126,3 сая төгрөг олгогдсон байна. Эрүүл мэндийн байгууллагуудын томилолтын зардал танагдсантай холбоотойгоор зарим албан хаагчдын томилолтын зардал бүрэн олгогдоогүй бөгөөд хүрсэн түвшин 85 % байна

		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь			Аймгийн Эрүүл мэндийн салбарт 2025 онд 8 их эмч, 13 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, 25 эрүүл мэндийн бусад ажилтан ажлын байраар тус тус хангагдсан байна. Хүрсэн түвшин: 85%
Хэрэгжилт						86.6 %
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	26,4 тэрбум төгрөг нийт төсөвт эзлэх хувь 79%	29,4 тэрбум төгрөг нийт төсөвт эзлэх хувь 79% Үр дүнгийн урамшуулал 1 тэрбум төгрөг байна.	Эрүүл мэндийн байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоол, 2022 оны 487 дугаар тогтоол, мөн 2024 оны 82, 83, 84, 238 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 90%.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг ЭМГ-т 5000, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 1000, аймгийн бусад эрүүл мэндийн байгууллага 3000	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг ЭМГ 15000, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 1000-5000, аймгийн бусад эрүүл мэндийн байгууллага 3000	2025 онд салбарын хэмжээнд нийт 1150 гаруй эрүүл мэндийн ажилтанд Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол болон Эрүүл мэндийн байгууллагуудын Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн унаа, хоолны зардалд 1121.5 сая төгрөг зарцуулсан байна. Биелэлт нь 95 хувь байна.

				төгрөгөөр тус тус тооцож олгох.	төгрөгөөр тус тус тооцож олгосон.	
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш %	87%	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг нэгдсэн аргачлал, асуулгаар, өөрсдийн төлөвлөгөөний дагуу ажилчдаас тодорхой давтамжтай, үе шаттайгаар тогтмол авч хэрэгжүүлсэн. Судалгааны үр дүнд гарсан санал, дүгнэлтийн дагуу тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан бөгөөд сэтгэл ханамжийн түвшин 86,6 хувьтай байна.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	2	Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын 75.3%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр өөрчлөлттэй гарсан эрүүл мэндийн ажилтны 90%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн бөгөөд 10% нь үргэлжлүүлэн эмчийн хяналтад эмчлүүлж байна. - Эрүүл мэндийн ажилтнуудын гепатитын В,С,D вирусийн халдварын тархалтын судалгаа гаргаж, дархлаажуулах зорилгоор нэгдсэн эмнэлгийн 22 тасаг, 13 СЭМТ, 4 ӨЭМТ, 5 ортой хувийн эмнэлгийн 1226 эмч, эмнэлгийн ажилчдаас дархлаажуулалтын хамралтыг судлахад • 1-р тун – 507 • 2-р тун – 255 • 3-р тун – 189 хамрагдсан байна. Дархлал тогтцын шинжилгээнд (HBsAb) нийт шинжилгээнд хамрагдсан – 210. Түүнээс • Бүрэн дархлаатай – 100 • 3 тунгаар дархлаажуулах шаардлагатай – 31 • Нэмэлт тун шаардлагатай – 79 хүн Дүгнэлт: Эмч эмнэлгийн ажилчдын дунд вакцины хамрагдалт хангалтгүй байна Дархлал тогтцын шинжилгээнд хамрагдсан эмч эмнэлгийн ажилтны тоо бага байна. Бүрэн дархлаа тогтоц нь хангалтгүй байна. Цаашид: 1.Эрүүл мэндийн бүх ажилтныг гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгийн бүрэн хамрагдалтад яаралтай

						хамруулах 2.Вакцин хийлгэсний дараах дархлал тогтцын шинжилгээг заавал хийж, эрсдэлтэй бүлгийг дахин дархлаажуулах 3.Шинээр ажилд орж буй ажилтныг дархлаажуулалтад заавал хамруулах 4.Ажлын байрны цус, биологийн шингэнд өртөлтийн эрсдэлийг бууруулах ХСХ-ын дэглэмийг сайжруулах 5.Дархлаажуулалт, шинжилгээний цахим болон бичгэн бүртгэлийг нэгтгэн хянах шаардлагатай байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	80%	80 %	Тайлангийн жилд нийт 20 эрүүл мэндийн байгууллагын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг 2025 оны 05 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 01-ний хооронд зохион байгууллаа. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах ёстой нийт 1200 гаруй ажилтнаас 80 хувь нь хамрагдсан байна.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Төлөвлөлтийн дагуу	Тайлант оны гүйцэтгэлээр	Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дугаар зүйлийн дагуу 147 эрүүл мэндийн ажилтанд 1245,4 сая төгрөг, 29.2 дугаар зүйлийн дагуу 29 эрүүл мэндийн ажилтанд 648,0 сая төгрөг олгогдсон. 3 дугаар шатлалын эмнэлэгт онош тодруулах эмчилгээнд хамрагдах 23 эрүүл мэндийн ажилтанд үндсэн байгууллагаас Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан нэг талын замын зардлыг шийдэж өгсөн байна. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх” АЗ сертификатын сургалтад хамрагдсан мэргэжилтний сургалтын төлбөрийг 30 гаруй эрүүл мэндийн ажилтанд 3 сая төгрөгийн эрүүл мэндийн байгууллагуудаас хариуцсан. 14 Эрүүл мэндийн байгууллагуудын 320 гаруй албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар ханган ажилласан. Биелэлт нь 80 % байна.
Хэрэгжилт						86.3 %
Дундаж хэрэгжилт						87

